

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орон нутгийн Хурлын 2022 оны нөхөн болон дахин сонгуулийг зохион байгуулахад Нийслэлийн Сонгуулийн хорооны зарцуулсан зардлын нэгдсэн төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2022/20/08-НА-СТА

Цахим хуудас: www.audit.mn	Аудитын нэгдүгээр хэлтсийн дарга, аудитын менежер: Ц.Бат-Өлзий Утас: 315578 Цахим хаяг: Bat-ulziits@audit.gov.mn
Улаанбаатар хот 2022 он	Аудитор: У.Оюунхүү Утас: 315578 Цахим хаяг: Oyunkhuu@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн сонгуулийн зардлын нэгдсэн тайлан.....	4
3. Аудитын тайлан	5
3.1 Ерөнхий зүйл	5
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	5
3.3 Тайлагналын үзэл баримтлал	6
3.4 Материаллаг байдал.....	6
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	6
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл	7
3.7 Аудитын гол асуудал.....	8
3.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал	8
4. Аудитын илрүүлэлт.....	9
4.1 Залруулсан алдаа	9
4.2 Зөвлөмж.....	9
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	10

Товчилсон үгийн жагсаалт

НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББ	Нягтлан бодох бүртгэл



НИЙСЛЭЛИЙН СОНГУУЛИЙН
ХОРООНЫ ДАРГА Ү.ГАНБОЛД
ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2022.08.11 № 1000
танай _____-ны № _____-т

Аудитын дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.8, 10.11 дүгээр заалтын дагуу орон нутгийн Хурлын 2022 оны нөхөн болон дахин сонгуулийг зохион байгуулах зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд аудит хийлээ.

Сонгуулийн хорооны хүлээх үүрэг, хариуцлага

Нийслэлийн Сонгуулийн хороо нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.10-д заасны дагуу Сонгуулийн ерөнхий хорооноос нийслэл, дүүрэгт хуваарилсан төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, зохих журмын дагуу харьяалах сонгуулийн хороодод хуваарилах, 10 дугаар зүйлийн 10.10, 10.11-д заасны дагуу зардлын зарцуулалт, гүйцэтгэлийн тайланг нэгтгэн гаргаж төрийн аудитын байгууллагад ирүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйл, Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар тушаалаар баталсан "Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам"-ын дагуу төлөвлөж, зарцуулан тайлагнасан эсэхэд дүгнэлт өгөх нь Нийслэл дэх Төрийн аудитын газрын үүрэг юм.

Дүгнэлтийн үндэслэл

Аудитыг хийхдээ Төрийн аудитын тухай, Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар тушаалаар баталсан "Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам", Сонгуулийн ерөнхий хороо болон

Нийслэлийн сонгуулийн хорооноос хуваарилсан төсөв, төсвийн хуваарийн тайлбар зэргийг шалгуур үзүүлэлт болгон ашигласан.

Зөрчилгүй дүгнэлт

Нийслэлийн сонгуулийн хороо нь орон нутгийн Хурлын 2022 оны нөхөн болон дахин сонгуулийг зохион байгуулсан сонгуулийн зардлын нэгтгэсэн тайланг Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйл, Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар тушаалаар баталсан "Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам"-д нийцүүлэн материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2. Аудит хийсэн сонгуулийн зардлын нэгдсэн тайлан

(төгрөгөөр)

№	Зардлын ангилал	Аудит хийсэн төсөв	Аудит хийсэн гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Сонгуулийн дүн мэдээний маягт, албан бичгийн хэвлэмэл хуудас, үнэмлэх хэвлүүлэх зардал	100,000.00	100,000.00	-
2	Сонгуулийн бичиг баримт, техник хэрэгсэл болон сурталчилгааны материалыг нийслэл, дүүргийн сонгуулийн хороо, санал авах байранд хүргэх, буцаан татах зардал	1,534,000.00	1,534,000.00	-
3	Сонгуулийн автоматжуулсан систем ашиглахтай холбоотой гарах зардал	240,000.00	240,000.00	-
4	Дүн мэдээ дамжуулах зардал	260,000.00	260,000.00	-
5	Санал авах байр бэлтгэх, тохижуулах зардал	900,000.00	900,000.00	-
6	Сургалт, сурталчилгааны зардал	8,520,000.00	8,519,650.00	350.00
7	Сонгуулийн байгууллагын ажилтан, МТБ-ийн гишүүн, даамлын ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал	28,200,000.00	28,200,000.00	-
8	Бичиг хэргийн зардал	1,050,000.00	1,050,000.00	-
9	Шуудан, холбооны зардал	1,150,000.00	1,150,000.00	-
10	Унааны зардал	3,080,000.00	3,080,000.00	-
11	Томилолтын зардал	284,000.00	284,000.00	-
12	Болзошгүй зардал	1,500,000.00	1,500,000.00	-
	Нийт	46,818,000.00	46,817,650.00	350.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.8, 10.11 дүгээр заалтын дагуу орон нутгийн Хурлын 2022 оны нөхөн болон дахин сонгуулийг зохион байгуулсан Нийслэлийн Сонгуулийн хорооны сонгуулийн зардлын нэгдсэн төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитад Нийслэлийн болон Багахангай, Сонгинохайрхан дүүргийн Сонгуулийн хорооны сонгуулийн зардлын тайлан, холбогдох анхан шатны баримтыг хамруулсан.

Аудитыг НТАГ-ын Аудитын нэгдүгээр хэлтсийн аудитор У.Оюунхүү гүйцэтгэж, үе шатны хяналтыг хэлтсийн дарга, аудитын менежер Ц.Бат-Өлзий, тэргүүлэх аудитор М.Эрдэнэжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Нийслэлийн Сонгуулийн хорооны дарга, нягтлан бодогч нар орон нутгийн Хурлын 2022 оны нөхөн болон дахин сонгуулийг зохион байгуулсан Нийслэлийн болон Багахангай, Сонгинохайрхан дүүргийн Сонгуулийн хорооны сонгуулийн зардлын тайланг нэгтгэн гаргаж, аудит хийлгэхээр НТАГ-т 2022 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 09 тоот албан бичгээр ирүүлсэн.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Нийслэл, дүүргийн Сонгуулийн хороо нь, нийслэл, дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд орон нутгийн Хурлын сонгуулийг зохион байгуулж явуулах чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Санхүүгийн хувьд Нийслэлийн Сонгуулийн хороо нь Сонгуулийн ерөнхий хорооноос нийслэл, дүүрэгт хуваарилсан төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, зохих журмын дагуу харьяалах Багахангай, Сонгинохайрхан дүүргийн сонгуулийн хороодод хуваарилах, зардлын зарцуулалт, гүйцэтгэлийн тайланг нэгтгэн гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Нийслэл, дүүргийн сонгуулийн байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын зохион байгуулалт, хэрэгжилт тодорхой хэмжээнд үр нөлөөтэй байна.

Сонгуулийн байгууллагын мөрдөж байгаа Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар тушаалаар баталсан "Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам"-ын холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Нийслэлийн Сонгуулийн хороо, дүүргийн сонгуулийн хорооны, дүүргийн сонгуулийн хороо харьяалах хэсгийн хорооны сонгуулийн зардлыг төлөвлөж хуваарилах, зарцуулалтад хяналт тавих үүрэгтэй бөгөөд зарим зардлын зарцуулалтад тавих хяналт сул байна.

3.3 Тайлагналын үзэл баримтлал

Сонгуулийн зардлын тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр сонгуулийн зардлын тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд аудитын зорилго оршино.

Орон нутгийн Хурлын 2022 оны нөхөн болон дахин сонгуулийг зохион байгуулсан Нийслэлийн Сонгуулийн хорооны сонгуулийн зардлын нэгдсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг стандарт, журам заавар, тайлагнал, толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны сонгуулийн зардлын тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардлын 46,817.7 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 936.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сонгуулийн зардлын нэгдсэн тайлангаар орон нутгийн Хурлын 2022 оны сонгуулийг зохион байгуулахад 46,817.7 мянган төгрөг зарцуулснаас Нийслэлийн Сонгуулийн хороо 31.4 хувийг, Сонгинохайрхан дүүргийн Сонгуулийн хороо 39.6 хувийг, Багахангай дүүргийн Сонгуулийн хороо 29.0 хувийг зарцуулжээ.

Хүснэгт 1. Нийслэл, дүүргийн сонгуулийн хорооны сонгуулийн зардлын зарцуулалт

(төгрөг)

№	Зардлын ангилал	Нийслэлийн Сонгуулийн хороо	Сонгинохайрхан дүүргийн Сонгуулийн хороо	Багахангай дүүргийн Сонгуулийн хороо	Нэгдсэн тайлан
1	Сонгуулийн дүн мэдээний маягт, албан бичгийн хэвлэмэл хуудас, үнэмлэх хэвлүүлэх зардал	-	50,000.00	50,000.00	100,000.00
2	Сонгуулийн бичиг баримт, техник хэрэгсэл болон сурталчилгааны материалыг нийслэл, дүүргийн сонгуулийн хороо, санал авах байранд хүргэх, буцаан татах зардал	-	170,000.00	1,364,000.00	1,534,000.00
3	Сонгуулийн автоматжуулсан систем ашиглахтай холбоотой гарах зардал	-	160,000.00	80,000.00	240,000.00
4	Дүн мэдээ дамжуулах зардал	-	130,000.00	130,000.00	260,000.00
5	Санал авах байр бэлтгэх, тохижуулах зардал	-	600,000.00	300,000.00	900,000.00
6	Сургалт, сурталчилгааны зардал	8,449,650.00	40,000.00	30,000.00	8,519,650.00
7	Сонгуулийн байгууллагын ажилтан, МТБ-ийн гишүүн, даамлын ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал	4,700,000.00	14,100,000.00	9,400,000.00	28,200,000.00
8	Бичиг хэргийн зардал	450,000.00	350,000.00	250,000.00	1,050,000.00
9	Шуудан, холбооны зардал	400,000.00	450,000.00	300,000.00	1,150,000.00
10	Унааны зардал	700,000.00	1,470,000.00	910,000.00	3,080,000.00
11	Томилолтын зардал	-	-	284,000.00	284,000.00
12	Болзошгүй зардал	-	1,000,000.00	500,000.00	1,500,000.00
Нийт зардал		14,699,650.00	18,520,000.00	13,598,000.00	46,817,650.00
Эзлэх хувь		31.4%	39.6%	29.0%	100.0%

Зардлын ангиллаар авч үзвэл 28,200.0 мянган төгрөгийг сонгуулийн хороо, хэсгийн хорооны гишүүд, нягтлан бодогч, мэдээлэл технологийн даамлуудын урамшуулал, хоолны зардалд, 8,519.7 мянган төгрөгийг сургалт, сурталчилгааны зардалд зарцуулсан нь голлох хувийг буюу нийт зардлын 78.4 хувийг эзэлж байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 10.1-д заасны дагуу орон нутгийн Хурлын сонгуулийг зохион байгуулахтай холбогдсон гарах зардлыг Сонгуулийн ерөнхий хорооны төсөвт тусгаж, улсын төсвөөс санхүүжүүлэх, аймаг, нийслэлийн Сонгуулийн хороо нь уг хуулийн 16.2.10-д заасны дагуу Сонгуулийн ерөнхий хорооноос хуваарилсан төсвийн хөрөнгийг зохих журмын дагуу харьяалах сонгуулийн хороонд хуваарилах үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Сонгуулийн ерөнхий хорооноос 2022 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 3/51 тоот албан бичгээр эхний санхүүжилтийн 6,800.0 мянга, 6 дугаар сарын 07-ны өдрийн 2/82 тоот албан бичгээр шинэчлэн 45,708.0 мянган төгрөгөөр төсвийг баталж, төсвийн санхүүжилтийг хэрхэн төлөвлөсөн талаарх дэлгэрэнгүй тайлбарын хамт Нийслэлийн Сонгуулийн хороонд ирүүлжээ.

Харин 6 дугаар сарын 20-ны өдрийн 3/97 тоот албан бичгээр төсвийн хуваарийг шинэчлэн баталж нийслэл, дүүрэгт 46,818.0 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж ирүүлсэн ч нэмж баталсан 1,110.0 мянган төгрөгийг хэрхэн төлөвлөсөн талаарх тайлбарыг ирүүлээгүй байна.

Нийслэлийн сонгуулийн хороо нь Сонгуулийн ерөнхий хорооноос баталж санхүүжүүлсэн төсвийг нийслэл, дүүргийн сонгуулийн байгууллагад хуваарилахдаа дээр дурдсан төлөвлөлт нь тодорхой тайлбаргүйгээр нэмж батлагдсан 1,110.0 мянган төгрөгийг өөртөө зарцуулахаар төлөвлөж санхүүжилтийг хуваарилсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Сонгуулийн ерөнхий хорооноос баталж ирүүлсний дагуу нийслэл, дүүргийн сонгуулийн хороо сонгууль зохион байгуулахад 46,818.0 мянган төгрөг төлөвлөж, гүйцэтгэлээр 46,817.7 мянган төгрөг зарцуулж, үлдэгдэл 0.3 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлжээ. Энэ нь Нийслэлийн сонгуулийн хорооны сургалт, сурталчилгааны зардалд 8,520.0 мянган төгрөг төсөвлөснөөс сургалтын зардалд 450.0 мянга, сурталчилгааны зардалд 7,999.7 мянга, нийт 8,519.7 мянган төгрөг зарцуулсантай холбоотой байна.

Нийслэл, дүүргийн сонгуулийн хорооны батлагдсан нийт төсөв, гүйцэтгэл, түүний хэмнэлтийг зардлын ангилал тус бүрээр энэ тайлангийн 2 дугаар хэсэгт харуулав.

3.7 Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлага, хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл байдал үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

3.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар шатах тослох материалын зарцуулалтын анхан шатны баримтыг анхаарах шаардлагатай.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3,282.0 мянган төгрөгийн 6 алдаа зөрчил илэрч, зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдаа илрээгүй тул санхүүгийн тайланд залруулга хийгээгүй.

4.2 Зөвлөмж

Бичиг хэрэг, түлш шатахуун, томилолтын зардлын зарцуулалттай холбоотой анхаарвал зохих дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

Илрүүлэлт:

1. Нийслэлийн Сонгуулийн хорооны бичиг хэргийн зардлаас 25ш дэвтэр, балыг нийт 250.0 мянган төгрөгөөр худалдан авсныг албан хэрэгцээнд нэрээр сонгуулийн хорооны нэг гишүүн шаардах хуудсаар авсан боловч зориулалт, зарцуулалт нь тодорхойгүй, нотлох анхан шатны баримтыг хавсаргаагүй;
2. Албан ажлын хэрэгцээ, зайлшгүй олгох шаардлагатай эсэхийг харгалзахгүйгээр Нийслэлийн Сонгуулийн хорооны 9 гишүүн бүрд 50.0-100.0 мянган төгрөгийн шатахууны талон тараан олгосон, зарцуулалт, зориулалтыг хянахгүй, тооцоог бодохгүйгээр тус бүрийн хөтөлсөн замын хуудсыг хавсарган нийтдээ 700.0 мянган төгрөгийг зардалд бүртгэсэн. Замын хуудасны гүйлтийг хянаж үзэхэд:
 - a. 6 дугаар сарын 18-19-ны өдрүүдэд Багахангай дүүргийн Сонгуулийн хороо руу явахад 5 гишүүн өөр өөрсдийн машинаар ганц ганцаараа явж тус бүрдээ 200-280км туулснаар замын хуудас хөтөлж түүнд ногдох шатахууныг тус бүрдээ зардалд бүртгэсэн, ямар ажлаар явсан талаарх албан томилолтын удирдамж, тайлан байхгүй.
 - b. Сонгинохайрхан дүүргийн сонгуулийн хороо, хэсгийн хороод руу 8 гишүүн тус бүрдээ өөр өөрсдийн машинаар тус тусдаа 60-150км явж очсон гэж замын хуудас хөтөлснийг хянахгүйгээр зардалд бүртгэсэн, ямар ажлаар явсан талаарх ажлын удирдамж, тайлан байхгүй.
3. Сургалт, семинарыг цахим хэлбэрээр зохион байгуулж, холбогдох зардлыг хэмнэж ажиллах шаардлагыг хэрэгжүүлэхгүйгээр Нийслэлийн Сонгуулийн хорооноос сургалтын цайны зардалд гэж 450.0 мянган төгрөгийг Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газарт шилжүүлсэн, сургалтын төлөвлөгөө, зохион байгуулсан хугацаа, багш, оролцогчдын мэдээлэл, сургалтыг баримтжуулсан фото зураг, зохион байгуулалт, үр дүнгийн талаарх тайлан, мэдээлэл байхгүй, зохион байгуулсан эсэх нь тодорхойгүй, нэхэмжлэх хуудаснаас өөр нотлох анхан шатны баримтыг хавсаргаагүй;
4. Сонгинохайрхан дүүргийн Сонгуулийн хороо цахилгааны эх үүсвэр бэлтгэх зардал гэж 160.0 мянган төгрөгийг автомашины угаалга, засвар үйлчилгээ, дэлгүүр бөөний худалдаа, барилгын засварын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг Эвт хийморь багана ХХК-д шилжүүлэн олгосон ч ямар ажил үйлчилгээ үзүүлсэн нь тодорхойгүй, гэрээ, тайлан зэрэг нотлох анхан шатны баримтыг хавсаргаагүй;
5. Сонгинохайрхан дүүргийн Сонгуулийн хороо албан ажлын хэрэгцээ, зайлшгүй олгох шаардлагатай эсэхийг харгалзахгүй, зориулалт зарцуулалтыг хянахгүйгээр дүүргийн болон хэсгийн хорооны дарга, зарим гишүүдэд шатахууны талон тараан олгосон бөгөөд хэдэн сарын хэдэнд, хаашаа, ямар ажлаар хэдэн километр зам туулсан тухай замын хуудаст гүйлт бүрээр дэлгэрэнгүй бүртгэж хөтлөхгүйгээр 780.0 мянган төгрөгт ногдох замын хуудсыг бөөн дүнгээр хөтөлсөн;
6. СЕХ-оос саналын хуудас, тоолох тоног төхөөрөмж хүлээн авах, хүлээлгэн өгөхөд зориулан томилолтын зардлыг төсөвлөсөн байхад Багахангай дүүргийн

Сонгуулийн хороо нь туршлага судлахаар Сонгинохайрхан дүүрэгт ажиллахаар 320.0 мянга, маягт захиалах, хэвлүүлж авахаар 128.0 мянга, томилолтын төсөвт байрны зардлыг тусгаагүй, зөвхөн хоолны зардлыг олгохоор төсвийн тайлбарыг ирүүлсэн байхад байрны зардалд 440.0 мянга, албан томилолтын зардлын тарифыг мөрдөхгүйгээр 72.0 мянга, нийт төсөвт тусгагдаагүй 942.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Эдгээр нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.3. "хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, арга хэмжээ нь хамгийн бага зардлаар хамгийн өндөр үр дүнг хангахад чиглэсэн байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.5. "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулна", Сангийн сайдын "Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай" 2018 оны 301 дүгээр тушаал, 2022 оны 120 дугаар тушаал, Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар тушаалаар баталсан "Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам"-ын 3.6. "Сонгуулийн хороод хуваарилсан төсвийг эдийн засгийн ангиллын дагуу үр ашигтай, хэмнэлттэй зарцуулна", Сонгуулийн Ерөнхий хорооны 2022 оны 3/51, 3/82 тоот албан бичгээр хавсралт "Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны төсвийн хуваарийн тухай тайлбар"-т тусгагдсаныг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

- Бичиг хэрэг, түлш шатахуун, томилолтын зардлын анхан шатны баримтын бүрдүүлэлтэд анхаарч, зардлыг зориулалт, зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах.
- Зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

(мян.төг)											
д/д	Алдаа, зөрчлийн утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бичиг хэрэг, түлш шатахуун, томилолтын зардлын зарцуулалттай холбоотой асуудал:											
1	Анхан шатны баримтын бүрдүүлэлт, хяналт хангалтгүй	6	3,282.0							6	3,282.0
	Нийт	6	3,282.0							6	3,282.0